*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАЛ-ЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 64 | 64 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1.<br>Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>ХААИС-д суралцах | 15 | 15 |
| 3. | Арга хэмжээ 3.<br>Байгууллагаас болон төслөөс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | 15 | 15 |
| 4. | Арга хэмжээ 4.<br>Дотоодын болон олон улсын хурал, зөвлөгөөнд оролцож, мэдлэг, мэдээлэл авах | 15 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | 15 |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 15 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 15 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 64 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | ..... *оноо* |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 94. |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ГАЗРЫН ДАРГА ........ (А.ЭНХМАНЛАЙ)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

............................... *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА ........................... (Ж.ГАЛ)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

....................... *(огноо)*

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.11.** **Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаатай холбогдсон орон зайн мэдээллийн менежментийн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хууль эрх зүй, бодлогын орчин, хөрөнгө оруулалт, орон зайн стандартын тогтолцоог бүрдүүлэх** | | | | | | | |
| **1.11.1** | **Олон улсын ISO/TC211 19000 цуврал стандартыг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **1 стандарт** | **Орон зайн суурь 18 өгөгдлийн техник үзүүлэлтийг Үндэсний стандарт болгон батлуулсан.** | **Үндэсний стандартын төслийг эцэслэн боловсруулагдсан байна.** | | |
| 1.11.1.1 | Үндсэн стандартын төсөл боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | “ISO 19157 Орон зайн мэдээлэл-Өгөгдлийн чанар” стандарт | - Орон зайн суурь 18 өгөгдлийн техник үзүүлэлтийг Үндэсний стандарт болгон батлуулсан.<br>- 2022 онд ISO 19131 Өгөгдөл техникийн үзүүлэлт стандартыг батлуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Бусад байгууллагуудаас санал авах ажлыг Стандарт, хэмжил зүйн газартай хамтран зохион байгуулсан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Газрын салбарын стандартчиллын техникийн хороо (ТХ-36)-оор хэлэлцүүлж, батлуулах | ISO 19157-1:2023 стандартын төслийн орчуулгга хийх төсөв батлагдаагүй тул 112 хуудас стандартыг нэгжийн албан хаагчид хувааж орчуулсан.<br>Стандартын төслийн орчуулгад сайжруулалт, хянан тохиолдуулга хийлгэхээр зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг 2024 оны 10 дугаар сард шалгаруулж, гүйцэтгэлийг 2024 оны 11 дүгээр сарын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлыг зохион байгуулсан байна. | 05-ны өдөр хүлээн авсан. Тус ажлын гүйцэтгэлд ОЗӨДБГ-аас дүгнэлт гаргаж Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгсөн. ISO 19157-1:2023 стандартын төслийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2 дугаар хурлаар хэлэлцүүлж, чанарын үнэлгээний тайлан хийж үр дүнг туршилт үзсэний дараа дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Тус стандартыг Газрын салбарын стандартчиллын техникийн хороо (ТХ-36)-оор хэлэлцүүлэхээр 2024 оны 12 дугаар сард албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.<br>Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| **1.22.1** | **Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын их хуралд өргөн барих** | **Үйл ажиллага а** | **Хуулийн төсөл-1** | **Улсын хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан.** | **Хуулийн төслийг Улсын их хуралд өргөн барьсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.1.7 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл | Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг шинэчлэн боловсруулж БХБЯ-нд хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулах ажлыг зохион байгуулах, дэд шатны байгууллагуудыг нэмэлт судалгаа, мэдээллээр хангаж ажиллана.<br>**Жилийн эцэст:** | Байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж, БХБЯ-нд харьяалагдахгүй болсон тул тус хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдөр 1/628 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>МУ-ын Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусган сайжруулан дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэгдсэн.<br><br>Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгах санал боловсруулан газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/2421 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үндсэн чиглэлд тусгагдсан, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг | |



39

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагын хүрээнд боловсруулж, батлуулахаар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2024/327 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж байна. | |
| **1.22.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллагаа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт байна.** | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
| 1.22.2.2 | "Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ, цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах. | Үйл ажиллагаа | Засгийн газрын тогтоолын төсөл | - | **Жилийн эцэст:** Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, холбогдох саналыг авсан байна. Тогтоолын төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тогтоолын төслийг боловсруулж ДДЗХ-аар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Тус тогтоолын төслийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 1/2495 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>Тогтоолын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>(Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 173 дугаар тогтоол) | |



40

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.10 | "Геопорталыг ажиллуулах журам"-ын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах. | Үйл ажиллагаа | Журмын төсөл | | **Эхний хагас жилд:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд заасан Геопорталыг ажиллуулах журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Геопорталыг ажиллуулах журмын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Цахим системийн хөгжүүлэлтэй холбоотойгоор тус журмын төслийг дахин шинэчлэн боловсруулсан.<br>Тус журам Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй уялдан гарах учир хүлээгдэж байна. | |
| 1.22.2.11 | "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-ын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах. | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар баталсан Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам, Газрын даргын 2020 оны А/131 тушаалаар баталсан Газрын мониторингийн системийг ажиллуулах журам, Газрын даргын 2020 оны А/40 тушаалаар баталсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ыг мөрдөж ажилласан. | **Эхний хагас жилд:**<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагааны журмын төсөлд холбогдох яам болон захиргааны байгууллагаас санал авч, боловсруулсан байна. Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт батлуулахаар хүргүүлсэн байна. | "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-ын төслийг боловсруулах үүрэг бүхий Газрын даргын А/194 дугаартай ажлын хэсгийн хурлыг 5 удаа зохион байгуулж, журмын төслийг боловсруулсан. Журмын төслийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн ДДЗХ-аар хэлэлцүүлсэн. (дэмжигдээгүй)<br>Журмын төсөлд олон нийтээс санал авах ажлыг 28 хоногийн турш байгууллагын цахим хуудсаар, холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас 1/1253-1/1258 дугаартай албан | |



41

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгээр, нэгжийн удирдлагуудаас саналын хуудсаар дамжуулан зохион байгуулж, саналыг нэгтгэсэн.<br>Журмын төслийн хэлэлцүүлэгийн 4 удаа зохион байгуулж 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр эцэслэсэн. Үүнд:<br>- 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр;<br>- 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр;<br>- 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр;<br>- 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр;<br>Тус журмын төслийг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр газрын удирдлагуудад танилцуулж батлуулахаар ЗГХЭГ-т хүргүүлэхийг дэмжсэн.<br>Хуулийн хэлтсийн дарга шинээр томилогдсонтой холбоотойгоор журмын төслийг хянуулан холбогдох саналыг тусган 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Хуулийн хэлтсийн даргад танилцуулж, 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр эцэслэж ЗГХЭГ-т хүргүүлэхээр болсон. | |



42

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Журмын төслийг батлуулахаар 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1/3383 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 1.22.2.12 | “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд тусгагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд заасан Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг газрын даргын дэргэдэх зөвлөлийг хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт батлуулахаар хүргүүлсэн байна. | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлж “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төслийг боловсруулсан.<br><br>Тус журам Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй уялдан гарах учир хүлээгдэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.13 | "Зохицуулах хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Дүрмийн төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд тусгагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд заасан Зохицуулах хорооны үйл ажиллагааны дүрмийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Зохицуулах хорооны үйл ажиллагааны дүрмийн төслийг боловсруулж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлж "Зохицуулах хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийг боловсруулсан.<br><br>Тус дүрэм Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй уялдан гарах учир хүлээгдэж байна. | |
| 1.22.2.14 | "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2023 оны А/198 дугаартай тушаалаар "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд заасан Зохицуулах хорооны үйл ажиллагааны дүрмийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан байна. | Агентлагийн даргын 2023 оны А/198 дугаар тушаалаар "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ахлаж ажилласан.<br>Журмын төслийг 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэн, журмын төслийг эцэслэн боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажлын хэсэг нийт 12 удаагийн уулзалтыг зохион байгуулж, журмын төслийг нийт 21 бүлэг, 150 зүйл бүхий агуулгатайгаар боловсруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагаа бүрийг журмын төсөлд нарийвчлан тусгаж, бусад хуульд заасан газартай холбоотой харилцааг тусган журмын төслийг эцэслэн боловсруулсан.<br><br>Журмын төслийг батлуулахаар 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1/3383 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 1.22.2.23 | "Нийтийн сервитут тогтооход нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журам"-ын төсөл боловсруулах | Үйл ажиллагаа | 1 журам | - | **Эхний хагас жилд:**<br>Нийтийн сервитут тогтооход нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журмын төслийг боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлж, баталсан байна. | "Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөн олговрын хэмжээг тооцох, нөхөн олговрыг тогтоох, нөхөн олговрыг дүйцүүлэн тооцож олгох журам"-ын төслийг шинээр боловсруулан Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу нөлөөллийн шинжилгээ хийж 2024 оны 03 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.28 | "Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах стратеги төлөвлөгөө"-г боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | Дэлхийн банкны зөвлөх багаас Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаарх авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020 он) гаргасан. | **Эхний хагас жилд:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд заасан Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах стратеги төлөвлөгөөг боловсруулан газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах стратеги төлөвлөгөөний дагуу 2024 онд хийж гүйцэтгэх ажлуудыг зохион байгуулсан байна. | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан "Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах стратеги төлөвлөгөө"-ний төслийг боловсруулсан.<br><br>Тус төлөвлөгөө Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлтэй уялдан гарах учир хүлээгдэж байна. | |
| 1.22.2.33 | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо, Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | 2023 онд 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 107 дугаар тушаалын дагуу салбарын хэмжээнд ашиглаж буй цахим систем, мэдээллийн санг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд нэгтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу нийт 16 байгууллагатай уулзалт хийхдээ Орон зайн суурь 18 өгөгдлийн MNS 6925-1- | |



46

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | 18:2021 талаар танилцуулга хийсэн.<br><br>Байгууллагын цахим хуудас, нүүр номонд тавигдсан мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилах ажлыг тухай бүр хийдэг. 2024 оны байдлаар 100 гаруй мэдээллийг түгээж ажиллав.<br><br>Хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэсэн. Үүнд:<br>- БНСУ-ын Төрийн Захиргаа, Аюулгүй Байдлын Яам, Газар, Геоматик (LX) Корпораци болон ГЗБГЗЗЕГ-ын "Хаягийн мэдээллийн систем"-ийн хамтын ажиллагааны талаар цуврал мэдээлэл;<br>- Хаягийн системийн ТЭЗҮ судалгааны үр дүнг танилцуулах;<br>- МУ-ын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар, БНСУ-ын Дотоод Хэрэг, Аюулгүй Байдлын Яамтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан тухай;<br>- Сөүлийн гудамжинд "Хаягийн тэмдэглэгээний | |



47

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дурсгалын самбар"-ыг байршуулах ёслолын үйл ажиллагаа;<br>- Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай ЗГ-ын 173 дугаар тогтоол. | |
| **1.22.3** | **Газрын харилцааны салбарын бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Бодлого, стратегийн баримт бичгүүд** | - | **Газрын харилцааны салбарт мөрдөх бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулж, батлуулсан байна.** | | |
| 1.22.3.1 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр оруулах саналыг боловсруулах | Үйл ажиллагаа | 1 хөтөлбөр | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах саналыг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан орон зайн өгөгдлийн дэд бүтэц, мэдээлэл технологи, геодези зураг зүйн ажлуудын биелэлтийг гаргаж 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдөр ГСШБТГ-т хүргүүлсэн.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр тусгах саналыг бусад нэгжүүдээс 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 1.22.3.2 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах | Үйл ажиллагаа | Жилийн төлөвлөгөөний төсөл | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан. | **Жилийн эцэст:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд холбогдох саналыг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төсвийн тооцоо, үнэлгээг гаргаж 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр СЭЗХ-т хүргүүлсэн. | |
| 1.23.3.3 | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулж, батлуулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | | **Жилийн эцэст:** "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулж, батлуулсан байна. | Стратеги төлөлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны А/264 дүгээр тушаалаар байгуулагдсан. Геодези, орон зайн мэдээллийн чиглэлээр 2024-2028 онд хийгдэх ажлын стратеги төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна. | - |
| **1.22.5** | **"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Салбарын хэмжээнд 4761 мод** | **2023 онд ГЗБГЗЗГ, Нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ нийт 2276 мод тарьсан.** | **"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд тайланг нэгтгэн гаргасан байна.** | | |



49

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.5.1 | "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарих | Үйл ажиллагаа | Өмнөх жилд тарьсан модны арчилгааны хувь | 2023 оны хавар салбарын хэмжээнд 2276 мод тарьсанаас 1933 мод нь ургасан. Тарьсан модны арчилгааг нэгжүүд хуваарийн дагуу гүйцэтгэж байна. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, тайланг салбарын хэмжээнд нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнгийн "Геодези, зураг зүйчдийн нэрэмжит төгөл"-д 2024 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан мод тарих үйл ажиллагаанд Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон. | |
| **1.22.6** | **"Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх** | **Үйл ажиллагаа** | **Санал өгсөн байдал** | **Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан.** | **"Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулахад санал өгсөн байна.** | | |
| 1.22.6.1 | "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа"-ны жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа"-ны жил болгон зарласан. | **Эхний хагас жилд:** Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан холбогдох нэгжүүдтэй хамтран хэрэгжилтийг хамтран зохион байгуулсан байна. | "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа"-ны жилийн хүрээнд Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан.<br>Орон сууц, амины орон сууцны зориулалтаар эзэмшүүлэх боломжтой газрын судалгаа гаргаж ирүүлэх тухай 2024.01.11- | |



30

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ны өдрийн 1/98 дугаартай албан бичгийг аймгийн газрын ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-нд хүргүүлж ирүүлсэн судалгааг нэгтгэн ДДЗХ-аар танилцуулсан.<br>Ажлын хэсгийн 2024 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан.<br>Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөний Говийн бүс (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр)-ийн салбар хуралдаанд 02 дугаар сарын 01-ээс 02-ны өдрүүдэд оролцов.<br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд "Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд сэдэвт салбар дундын хурал"-ыг Эдийн засаг, хөгжлийн яам, Шинжлэх Ухааны академийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Дорнод Монголын хуурай хээрийн ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал | |



51

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөлтэй хамтран төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн багш нар, эрдэмтэн, судлаачид, нийт 21 байгууллагын 70 гаруй төлөөллийн хурлыг 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. | |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.9** | **Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд шаардлагатай веб хуудас, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх хэрэглээнд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа, урсгал төсөв** | **3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт** | **8 вэб хуудас хэрэглээнд гаргасан.** | **3 цахим системийн хөгжүүлэлт хийж хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | | |
| 2.1.9.2 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн арчилгаа, нэмэлт хөгжүүлэлт хийх, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн 7 дэд систем:<br>1. Хот байгуулалт, төлөвлөлтийн систем; | - | **Эхний хагас жилд:**<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн байна.<br><br>**Жилийн эцэст:**<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн | Тус ажлын хүрээнд ГЗБГЗЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн А/46 тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан.<br>Холбогдох нэгжүүдээс санал авч АД/2024-31 дугаар бүхий Ажлын даалгаврыг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлуулсан. | |



52

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Газрын кадастрын систем;<br>3. Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн веб хуудас<br>4. Egazar гар утасны аппликэйшн | | архилгаа, нэмэлт хөгжүүлэлт хийх, хэвийн ажиллагааг хангаж харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг боловсруулж, тендерийн урилгыг 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр цахим системээр зарласан. Тус худалдан авах ажиллагааг Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж "Софт мастер" ХХК шалгарсан бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 2024/198 дугаартай гэрээ байгуулсан.<br><br>Тус ажлын явцын тайланг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч 2024 оны 11 сарын 13-ны өдөр 2024/ГБ33/51 дугаартай дүгнэлтээр Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгсөн.<br><br>"Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийн дэд бүтэц, серверүүдийн эд ангиудын хүчин чадлыг боломжит дээд түвшин хүртэл буюу CPU-u 89.4%, RAM-ийг 644.4% сайжруулсан.<br><br>21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас 2/3052 дугаартай албан бичгээр цахим системийн | |



53

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 онд хийгдэх хөгжүүлэлтийн ажлын саналыг авсан. | |
| 2.1.9.3 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийг орон зайн суурь өгөгдөл бүрдүүлэгч байгууллагуудын хэрэглээнд нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геопортал)-ийн хэрэглэгч байгууллагын тоо | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем Геопорталыг хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геопорталд орон зайн суурь өгөгдөл бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.<br><br>**Жилийн эцэст:** Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийг орон зайн зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч, ашиглагч, хадгалагч байгууллагуудын хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | 2024 оны 02 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Тагнуулын ерөнхий газрын 40 гаруй албан хаагчдад "Геопортал цахим системийн хэрэглээ" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>Орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэгч, хэрэглэгч 16 байгууллага буюу Боловсролын мэдээллийн технологийн төвийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн A/155, Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн A/128, Харилцаа, холбооны зохицуулах хорооны даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн A/97, Зам тээврийн хөгжлийн яамны сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн A/53, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн A/120, Соёлын яамны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны A/176, Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн A/16 дугаар тус тус тушаалуудаар орон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зайн суурь 18 өгөгдлийн стандартуудад нийцүүлэн газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд холбох ажлын хэсгүүд байгуулсан.<br>Мөн дээрх байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний хүрээнд манай байгууллагын холбогдох мэргэжилтнүүд дээрх ажлын хэсгүүдэд ажилласан.<br><br>Төмөр замын дээд сургууль сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар өндрийн тоон загвар авах хүсэх тухай албан бичиг ирүүлсэн . Тус хүсэлтийн дагуу 12.5 метрийн нарийвчлал бүхий Alos Palsar -ийн өндрийн тоон загвараар үйлчилгээ үзүүлсэн.<br>Геомэдээллийн холбооноос албан бичгээр хандсан хүсэлтийн дагуу Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Дархан, Өмнөговь аймгуудын ZY-3 хиймэл дагуулын 28 сцен түүхий датаг өгсөн. | |
| 2.1.9.4 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн арчилгаа, нэмэлт хөгжүүлэлт хийх, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хэвийн ажиллагаа | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем Геопорталыг хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геопортал цахим системийн хөгжүүлэлтийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны А/28 тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан.<br>Ажлын даалгаврыг холбогдох нэгжүүдээс санал авч боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр | |



55

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Жилийн эцэст:**<br>Геопортал цахим системийн шаардлагатай арчилгаа, нэмэлт хөгжүүлэлтийг хийж, хэвийн ажиллагааг хангасан байна. | АД/2024-10 дугаартай батлуулсан.<br><br>Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулж, Софт мастер ХХК шалгарч, 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2024/75 дугаар гэрээ байгуулж хөгжүүлэлтийн ажил эхэлсэн.<br>Тус гэрээт ажлын эцсийн тайлан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 24/149 дугаартай албан бичгээр ирсэн.<br><br>Софт мастер ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 24/121 дугаар албан бичгээр ирүүлсэн явцын тайланд захиалагчийн техникийн хяналт хийсэн.<br>Эцсийн тайланд захиалагчийн техникийн хяналт хийж, 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 2024/ГБЗЗ/46 дугаартай дүгнэлтээр Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн.<br><br>Системд хөгжүүлэлт хийснээр Геопортал цахим систем 2.0 хувилбарт шилжсэн. | |
| **2.1.10** | **Байрлалд суурилсан суурь орон зайн** | **Үйл ажиллагаа,** | **Геопорталаас орон зайн** | - | **Үндэсний орон зайн өгөгдлийн цахим** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **мэдээлэл, үйлчилгээгээр бусад байгууллагын мэдээллийн санг дэмжих, мэдээлэл хуваалцах, солилцох-геопортал** | **урсгал төсөв** | **өгөгдөл, мэдээлэл авч ашиглаж буй эрх бүхий байгууллагуудын тоо** | | **систем (nsdi.gov.mn)-д бусад байгууллагуудыг хандах боломжоор хангах, эрхийн зохицуулалт хийж хамтран ажилласан байна.** | | |
| 2.1.10.2 | Байгууллагын төвлөрсөн дата төвийн системүүдэд хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа, урсгал төсөв | - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем;<br>- Газрын кадастрын систем;<br>- Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем;<br>- Газрын мониторингийн систем;<br>- Газрын үнэлгээний систем;<br>- Газрын биржийн систем;<br>- Хот байгуулалтын кадастрын нэгдсэн систем; | 2021 "Систем Центр" ХХК-аар салбарын системүүдийн мэдээллийн аюулгүй байдалд аудит болон эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. | **Эхний хагас жилд:** Салбарын системүүдийн мэдээллийн аюулгүй байдалд аудит болон эрсдэлийн үнэлгээ хийлгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны А/09 тушаалаар Ажлын хэсэг байгуулан 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр АД/2024-01 дугаар бүхий Ажлын даалгаварыг батлуулсан.<br><br>Тус худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулсан бөгөөд 4 оролцогч тендерт оролцосноос "Инфо Сек Плас" ХХК шалгарч 2024 оны 02 сарын 20-ны өдрийн 2024/30 дугаар бүхий гэрээг байгуулсан. ГНСУНЦС-ийн эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйлчилгээ төлөвлөгөөний дагуу хийгдэж дуусан, ажлын гүйцэтгэлийг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулж, 2024/ГБЗЗ/13 дугаар бүхий ажил шалгаж, хүлээн авсан дүгнэлтээр баталгаажуулан Салбарын | |



57

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Хаягийн мэдээллийн систем; | | | архивын хэлтэст хүлээлгэн өгсөн.<br>Тус аудитын дүгнэлтийн хүрээнд "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийн дэд бүтэц, серверүүдийн эд ангиудын хүчин чадлыг боломжит дээд түвшин хүртэл сайжруулах ажлыг зохион байгуулсан. | |
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулагдсан арга хэмжээ** | **2023 онд 14 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.** | | |
| 4.1.8.3 | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, хурлаас гарсан үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хуралдааны тоо<br>- Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөл;<br>- Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл | 2023 онд Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл 6 удаа, Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөл 8 удаа хуралдсан. | **Эхний хагас жилд:**<br>Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг 9 удаа зохион байгуулсан.<br>9 удаагийн хурлаар 2 гэрээт ажлын үр дүн, 1 тэгшитгэн бодолт, 3 ажлын даалгавар, 1 журмын төсөл, 2 норм, дүрмийн төсөл, УБ хотын солбицолын дэд системийг хэлэлцүүлэв.<br>Хурлаар хэлэлцүүлсэн өндрийн I ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын үр дүн, 3 ажлын даалгавар, УБ хотын солбицолын дэд систем батлагдсан. | |



58

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2 норм дүрмийг дараагийн шатны хурлаар хэлэлцүүлэхээр дэмжсэн.<br>Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, Өгөгдлийн чанар стандартын төслийг тус тус хэлэлцүүлсэн. | |
